

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 55 дугаар зүйлийн 55.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт:

“4.1.5.гомдол хянан шийдвэрлэж дуусах хүртэл хугацаанд санхүүжилтийн эх үүсвэртэй байх.”

2/ 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт:

“4.7.Оролцогч хуулийн 28.1.3-т заасан захиалагчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш захиалагч тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг дахин хийж, тухайн оролцогчийн тендерээс ижил үндэслэлээр татгалзах шийдвэр хүргүүлсэн бол хуулийн 59.1-д заасан гомдол гаргах хугацааг эхний шийдвэрийг цахим системд нийтэлсэн өдрөөс тоолно.”

2.Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журмын 5 дугаар 5.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.5.Сангийн яам хуулийн 48.4-т заасан тендер шалгаруулалтын хувийн хэргээс цахим системд байршуулаагүй баримт бичгийг цахимаар, эсхүл бичгээр ажлын дөрвөн өдрийн дотор ирүүлэхийг захиалагчаас шаардана.”

3.Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журмын 1.1, 3.1, 3.4, 3.5, 3.7, 3.8, 3.9 дэх заалтын “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар” гэснийг “Монополын эсрэг газар” гэж, мөн журмын 2.2.4 дэх дэд заалтын, 3 дугаар бүлгийн гарчгийн, 3.3 дахь заалтын “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт” гэснийг “Монополын эсрэг газарт” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журмын 5.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тушаалын дагуу холбогдох өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Хууль, эрх зүйн газар (З.Энхболд)-т даалгасугай.

САЙД

Б.ЖАВХЛАН